

## ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны .. сарын .. өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.2, 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.9 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсантай холбогдуулан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдсанаар Үндэсний хөгжлийн газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн “Журам батлах тухай” А-158 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

Хянасан:

ДЭД ДАРГА

ТЗУХ-ийн дарга

БОНХБТХ-ийн дарга

ТЗУХ-ийн мэргэжилтэн

Боловсруулсан:

БОНХБТХ-ийн Ахлах мэргэжилтэн

БОНХБТХ-ийн мэргэжилтэн

Б.ДӨЛГӨӨН

Б.БУЛГАНЧИМЭГ

Н.ОРХОН

Д.ЭРДЭНЭБАЯР

Ц.Должинсүрэн

Х.Эрдэнэбулган

А.Нармандах

## **ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журмын зорилго нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах /цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дүгээр хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг салбараар, бүсээр, орон нутгийн түвшингээр болон урт, дунд, богино хугацаагаар ангилан, энгийн ойлгомжтой цогц хэлбэрээр олон нийтэд хүргэхэд тус сангийн зорилго, ач холбогдол оршино.

1.3.Мэдээллийн нэгдсэн санд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёог тус тус хэрэглэнэ.

1.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн удирдлага, зохион байгуулалт, журмын хэрэгжилт, хяналтыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

### **ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ**

2.1.Мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1.хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дүгээр хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн мэдээллийн сан;

2.1.2.аж үйлдвэрийн цахим мэдээллийн сан;

2.1.3.судалгаа, шинжилгээний баримт бичгийн сан;

2.1.3.1.“хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ;

2.1.3.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;

2.1.4.орон нутгийн хөгжлийн индекс;

2.1.5.хөрөнгө оруулалтын төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан;

2.1.6.орон зайн мэдээллийн их өгөгдлийн сан;

2.1.6.1.суурь орон зайн өгөгдөлд суурилсан өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ;

2.1.6.2.хиймэл оюун ухаан, орон зайн өгөгдөлд суурилсан ирээдүйн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

2.1.7.бусад холбогдох мэдээллийн сангууд.

## **ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1.Мэдээллийн нэгдсэн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Бүс, орон нутаг, салбар, байршил болон орон зайн асуудал хариуцсан холбогдох нэгж хариуцан зохион байгуулна.

3.2.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санд байршуулах энэхүү журмын 2.1.1-2.1.7-д заасан мэдээллийг хүлээн авах, солилцох хуваарийг батлах бөгөөд мэдээллийг ирүүлэх хугацаа бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаатай ижил байна.

3.3.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Бүс, орон нутаг, салбар, байршил болон орон зайн асуудал хариуцсан холбогдох нэгж Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх мэдээллийн төрөл, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлох бөгөөд мэдээлэл бүрдүүлэгч тус бүрт мэдээллийн санд нэвтрэх эрхийг олгохоос гадна мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах эсэх талаар зөвшөөрөл олгоно.

3.4.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна.

3.4.1.мэдээлэл бүрдүүлэгч нь мэдээллийн дэд сантай байх бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд туссан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаа тус бүрээр оруулах;

3.4.2.мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасаныг үндэслэн мэдээллийг бүрдүүлнэ;

3.4.3.мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн дагуу дээр дурдсан мэдээллийг цаасан болон цахим файл хэлбэрээр, орон зайн өгөгдлийн мэдээллийг вектор (shapefile, geodatabase, geojson, json), растер (тоон болон өндрийн нарийвчлалын зураг) форматтай ирүүлнэ;

3.4.4.мэдээллийн нэгдсэн санд оруулж байгаа өгөгдөл нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад мэдээлэл байх бөгөөд тус асуудлыг мэдээлэл бүрдүүлэгч бүрэн хариуцна;

3.4.5.мэдээлэл бүрдүүлэгч нь боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулна. Үүнд:

3.4.5.1.боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;

3.4.5.2.бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, хэлэлцүүлэгт оролцогчдын бүртгэл, мэдээлэл, өгсөн саналын товъёог;

3.4.5.3.хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгасан төсөл.;

3.4.6.мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь холбогдох эрх зүйн акт, тайлан, дүгнэлт, судалгаа, шинжилгээ, баримтаар баталгаажсан байна.

3.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэнтэй байна.

3.5.1.тус мэргэжилтний ажил үүргийн хуваарийг түүний ажлын байрны тодорхойлолтод тусгахыг тухайн шатны эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэж шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана;

3.5.2.хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ;

3.5.3.тус мэргэжилтний мэдээллийн сангийн ангилалт, бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт, боловсруулалттай холбоотой чадавхжуулах үүргийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна;

3.6.Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл ирүүлэхдээ тухайн мэдээллийг ирүүлэх эрх бүхий байгууллагыг төлөөлөх албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгийг дарж баталгаажуулна. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн байгууллага хариуцна.

3.7.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хяналт, баталгаажуулалтад процессын алдаа гарвал холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримтална.

3.8.Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй зөрсөн тохиолдолд батлагдсан баримт бичгийг эх сурвалж болгоно.

3.9.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг боловсруулах, бүрдүүлэх, мэдээлэл байршуулах, ашиглах, хадгалах, хамгаалах, нууцлал болон мэдээлэл түгээх үйл ажиллагаанд MNS 5140:2011, MNS 5552:2005, MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:2009; MNS ISO/IEC 13335-1:2009 зэрэг холбогдох стандарт шаардлагыг мөрдөн ажиллана

## **ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ**

4.1.Мэдээллийн нэгдсэн санг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн болон захиргааны бүх шатны байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбарын үйл ажиллагааны уялдаа

холбоог хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор албан ажлын хэрэгцээнд ашиглана.

4.2.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг солилцохдоо хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн мэдээлэл солилцооны систем болон цаасан хэлбэрээр дамжуулах ба заавал бүртгэл хөтөлнө.

4.4.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд ашиглах талаар холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудад хориглосноос бусад мэдээллийг ашиглуулах эсэхийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

4.5.Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн мэдээлэл солилцооны системтэй олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлыг хангах, олон нийтэд сурталчлах талаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн үндсэн дээр цахим хэлбэрээр холбогдож ажиллана.

4.6.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн нэгдсэн сан хариуцсан ажилтан нь жил бүрийн эцэст тухайн жилийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, мэдээлэл солилцооны талаарх мэдээллийг дээд шатны албан тушаалтанд танилцуулна.

4.7.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцооны системд холбогдох техникийн нөхцөл, ажиллах орчны стандартын шаардлагыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран батална.

4.8.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор солилцохыг хориглоно.

## **ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ЭРХ ОЛГОХ**

5.1.Энэхүү журамд заасан этгээд Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлтийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр гаргана.

5.2.Мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл авах хүсэлт нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан мэдээлэл ашиглах гэрээг энэ журмын 3.3-д заасан нэгж байгуулна.

5.3.Энэ журмын 5.2-д заасан гэрээнд дараах асуудлыг тусгана:

5.3.1.мэдээллийн үйлчилгээний хүрээ;

5.3.2.мэдээллийн үйлчилгээний нэр, төрөл;

5.3.3.ашиглалтын зориулалт;

5.3.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага;

5.3.5.мэдээллийн нэгдсэн сан, системийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөл, шаардлага;

- 5.3.6.мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг эзэмшигчийн тоо, албан тушаал, овог нэр,нууц үг;
- 5.3.7.гэрээний төлбөр, нөхцөл;
- 5.3.8.эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хязгаарлах нөхцөл;
- 5.3.9.гэрээний хүчинтэй байх хугацаа.

## **ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА**

6.1.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл, системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг хариуцан ажиллана.

6.2.Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны үе шат бүрт мэдээллийн нууцлалыг хангах, цахим халдлага, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан техник, программ хангамжийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх ба зохих хууль тогтоомж, стандартыг мөрдөж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

6.3.Байгалийн гамшигт эрсдэл, галын аюул, усны үер, нийтийг хамарсан үймээн самуун зэрэг давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлээс Мэдээллийн нэгдсэн санг хамгаалах менежментийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

6.4.Энэхүү журмыг зөрчин Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг хууль бусаар ашигласан, түгээсэн болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **ДОЛОО. САНХҮҮЖИЛТ**

7.1.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, эрхлэн хөтлөх, удирдах, мэдээллийн болон техникийн нөхцөлийг хэвийн хангах, хадгалах, хамгаалах, нууцлалын найдвартай байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг дараах эх үүсвэрээр тус тус санхүүжүүлнэ. Үүнд:

- 7.1.1.улсын төсөв;
- 7.1.2.холбогдох төсөл, хөтөлбөр.

## **НАЙМ. БУСАД**

8.1.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санг хэвийн ажиллуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд төрийн болон бүх шатны захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдтэй хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.



**“ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ ЖУРАМ”-Д  
ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТОВЪЁОГ**

№	Заалтын дугаар	Хуучин журмын заалт	Заалтын дугаар	Нэмэлт, өөрчлөлт орсон журмын заалт	Нэмэлт, өөрчлөлтийн талаар
1	Журмын нэр	ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ	Журмын нэр	ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ ЖУРАМ	“бүрдүүлэх, ашиглах” гэснийг “эрхлэн хөтлөх” гэж өөрчилсөн
2	<b>НЭГ</b>	<b>НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b>	<b>НЭГ</b>	<b>НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b>	Өөрчлөлт ороогүй.
3	1.1.	Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан /Цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх/-г бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1.1.	Энэхүү журмын зорилго нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах /цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Бүхэлд нь шинэчлэн найруулсан.
4	1.2.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2-6.5-д заасан урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн уялдааг хангах, тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч	1.2.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дүгээр хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг салбараар, бүсээр, орон нутгийн түвшингээр болон урт, дунд, богино хугацаагаар ангилан, энгийн ойлгомжтой цогц хэлбэрээр олон	Бүхэлд нь шинэчлэн найруулсан.



		хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэх, олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэхэд мэдээллийн нэгдсэн сангийн зорилго, ач холбогдол оршино.		нийтэд хүргэхэд тус сангийн зорилго, ач холбогдол оршино.	
5	1.3.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёог тус тус хэрэглэнэ.	1.3.	Мэдээллийн нэгдсэн санд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёог тус тус хэрэглэнэ.	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг хассан, Үндэсний хөгжлийн гэдгийн ард “бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн
6	1.4.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн удирдлага, зохион байгуулалт, журмын хэрэгжилт, хяналтыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.	1.4.	Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн удирдлага, зохион байгуулалт, журмын хэрэгжилт, хяналтыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг хассан, Үндэсний хөгжлийн гэдгийн ард “бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн
7	<b>ХОЁР</b>	<b>МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ</b>	<b>ХОЁР</b>	<b>МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ</b>	Өөрчлөлт ороогүй.
8	2.1.	Мэдээллийн нэгдсэн сан нь Монгол улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:	2.1.	Мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:	“улсын” гэснийг “Улсын” гэж өөрчилсөн.
9	2.1.1.	хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2–6.5 дугаар	2.1.1.	хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн	“6.2-6.5” гэснийг “6.2, 6.5, 6.7, 6.8,

		зүйлд заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрлийн дагуух мэдээллийн сан;		6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дүгээр хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн мэдээллийн сан;	6.9” гэж өөрчилсөн, “төрлийн дагуух” гэснийг хассан.
10	2.1.2.	аж үйлдвэрийн мэдээллийн сан;	2.1.2.	аж үйлдвэрийн цахим мэдээллийн сан;	“цахим” гэж нэмсэн.
11	2.1.3.	судалгаа, шинжилгээний баримт бичгийн сан;	2.1.3.	судалгаа, шинжилгээний баримт бичгийн сан;	Өөрчлөлт ороогүй.
12	2.1.3.1.	“хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 9.3-д заасан нөхцөл байдлын дүн шинжилгээ;	2.1.3.1.	“хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ;	2.1.3.1 болон 2.1.3.2 дахь заалтуудыг нийлүүлж өөрчлөн найруулсан.
13	2.1.3.2.	“хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 9.12-т заасан нөлөөллийн урьдчилсан үнэлгээ;			2.1.3.1 болон 2.1.3.2 дахь заалтуудыг нийлүүлж өөрчлөн найруулсан.
14	2.1.3.3.	хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл, батлагдсан хувилбар;	2.1.3.2.	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;	Дугаарлалтыг 2.1.3.2 болгож, “батлагдсан хувилбар” гэдгийг хассан
15	2.1.3.4.	байгаль орчны стратегийн үнэлгээ;	2.1.3.4.		Бүхэлд нь хассан.
16	2.1.4.	орон нутгийн хөгжлийн индекс;	2.1.4.	орон нутгийн хөгжлийн индекс	Өөрчлөлт ороогүй.
17	2.1.5.	төсвийн нэгдсэн санд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн мэдээллийн сан;	2.1.5.	хөрөнгө оруулалтын төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан;	Хуучин 2.1.5-ыг хасаж шинээр “хөрөнгө оруулалтын төслүүдийн

					нэгдсэн мэдээллийн сан;" гэж нэмсэн
18	2.1.6.	өөр холбогдох мэдээллийн сангууд.	2.1.6.	Орон зайн мэдээллийн их өгөгдлийн сан;	Хуучин 2.1.6 дахь заалтыг 2.1.7-руу шилжүүлж "Орон зайн мэдээллийн их өгөгдлийн сан" гэж шинээр нэмсэн
19			2.1.6.1.	суурь орон зайн өгөгдөлд суурилсан өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ;	Шинээр нэмсэн.
20			2.1.6.2.	хиймэл оюун ухаан, орон зайн өгөгдөлд суурилсан ирээдүйн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;	Шинээр нэмсэн.
21			2.1.6.	Бусад холбогдох мэдээллийн сангууд.	Хуучин 2.1.6 дахь заалтын "өөр" гэснийг бусад гэж өөрчилсөн.
22	ГУРАВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА</b>	ГУРАВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА</b>	"САНГ" гэснийг "САНГИЙН" гэж өөрчилсөн
23	3.1.	Мэдээллийн нэгдсэн сангийн төлөвлөлт, үйл ажиллагаа, гүйцэтгэл үнэлгээ, сайжруулалт, тогтвортой ажиллагааг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Салбарын хөгжлийн бодлого	3.1.	Мэдээллийн нэгдсэн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын	Бүхэлд шинэчлэн найруулсан.

		зохицуулалтын газар эрхлэн хариуцна.		Бүс, орон нутаг, салбар, байршил болон орон зайн асуудал хариуцсан холбогдох нэгж хариуцан зохион байгуулна	
24	3.2.	Төрийн болон захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэгч байна.	3.2.	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санд байршуулах энэхүү журмын 2.1.1-2.1.7-д заасан мэдээллийг хүлээн авах, солилцох хуваарийг батлах бөгөөд мэдээллийг ирүүлэх хугацаа бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаатай ижил байна.	Хуучин 3.2 дахь хэсгийг 3.4-рүү шилжүүлж өөрчлөн найруулсан.
25	3.3.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санд байршуулах энэхүү журмын 2.1.1-2.1.4-д заасан мэдээллийг хүлээн авах, солилцох хуваарийг батлах бөгөөд мэдээллийг ирүүлэх хугацаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаатай ижил байна.	3.3.	3.3.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Бүс, орон нутаг, салбар, байршил болон орон зайн асуудал хариуцсан холбогдох нэгж Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх мэдээллийн төрөл, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлох бөгөөд мэдээлэл бүрдүүлэгч тус бүрт мэдээллийн санд нэвтрэх эрхийг олгохоос гадна мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл оруулах эсэх талаар зөвшөөрөл олгоно.	3.3 дахь заалтыг 3.2-руу шилжүүл шинээр заалт оруулсан.
26	3.4.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг боловсруулах, бүрдүүлэх, мэдээлэл	3.4.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн	Хуучин 3.2 дахь заалтыг шилжүүлж

		байршуулах, ашиглах, хадгалах, хамгаалах, нууцлал болон мэдээлэл түгээх үйл ажиллагаанд MNS 5140:2011, MNS 5552:2005, MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:209; MNS ISO/IEC 13335-1:2009 зэрэг холбогдох стандарт шаардлагыг мөрдөн ажиллана.		бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна.	өөрчлөн найруулсан.
27			3.4.1.	мэдээлэл бүрдүүлэгч нь мэдээллийн дэд сантай байх бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд туссан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаа тус бүрээр оруулах;	Шинээр нэмсэн.
28			3.4.2.	мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасаныг үндэслэн мэдээллийг бүрдүүлнэ;	Шинээр нэмсэн.
29			3.4.3.	мэдээлэл бүрдүүлэгч нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн дагуу дээр дурдсан мэдээллийг цаасан болон цахим файл хэлбэрээр, орон зайн өгөгдлийн мэдээллийг вектор (shapefile, geodatabase, geojson, json), растер (тоон болон өндрийн нарийвчлалын зураг) форматтай ирүүлнэ;	Шинээр нэмсэн.

30			<b>3.4.4.</b>	мэдээллийн нэгдсэн санд оруулж байгаа өгөгдөл нь Монгол Улсын хууль тогтоомжоор нууцад хамруулснаас бусад мэдээлэл байх бөгөөд тус асуудлыг мэдээлэл бүрдүүлэгч бүрэн хариуцна;	Шинээр нэмсэн.
31			<b>3.4.5.</b>	мэдээлэл бүрдүүлэгч нь боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулна. Үүнд:	Шинээр нэмсэн.
32			<b>3.4.5.1.</b>	боловсруулж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл;	Шинээр нэмсэн.
33			<b>3.4.5.2.</b>	бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, хэлэлцүүлэгт оролцогчдын бүртгэл, мэдээлэл, өгсөн саналын товъёог;	Шинээр нэмсэн.
34			<b>3.4.5.3.</b>	хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгасан төсөл.	Шинээр нэмсэн.
35	<b>3.5.</b>	Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх мэдээллийн төрөл, түүнд тавигдах шаардлагыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн санд байршуулах зөвшөөрөл олгоно.	<b>3.5.</b>	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэнтэй байна.	3.5 дахь заалтыг 3.3 дахь заалтруу шилжүүлж бүхэлд нь өөрчлөн найруулсан.

36			3.5.1.	тус мэргэжилтний ажил үүргийн хуваарийг түүний ажлын байрны тодорхойлолтод тусгахыг тухайн шатны эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэж шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана;	Шинээр нэмсэн.
37			3.5.2.	хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн мэдээллийг бүрдүүлнэ;	Шинээр нэмсэн.
38			3.5.3.	тус мэргэжилтний мэдээллийн сангийн ангилалт, бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт, боловсруулалттай холбоотой чадавхжуулах үүргийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна;	Шинээр нэмсэн.
39	3.6.	Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцах ажилтныг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтан томилж, чөлөөлнө.	3.6.	Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл ирүүлэхдээ тухайн мэдээллийг ирүүлэх эрх бүхий байгууллагыг төлөөлөх албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгийг дарж баталгаажуулна. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн байгууллага хариуцна.	Хуучин 3.6 дахь заалтыг хасаж, 4.3 дахь заалтын дугаарлалтыг өөрчилсөн.
40	3.7.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хяналт, баталгаажуулалтад процессийн алдаа гарвал холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримтална.	3.7.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хяналт, баталгаажуулалтад процессын алдаа гарвал холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримтална.	Өөрчлөлт ороогүй.
41	3.8.	Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл батлагдсан бодлогын	3.8.	Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл батлагдсан хөгжлийн	

		баримт бичигтэй зөрсөн тохиолдолд батлагдсан бодлогын баримт бичгийг эх сурвалж болгоно.		бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй зөрсөн тохиолдолд батлагдсан баримт бичгийг эх сурвалж болгоно.	
42			3.9.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг боловсруулах, бүрдүүлэх, мэдээлэл байршуулах, ашиглах, хадгалах, хамгаалах, нууцлал болон мэдээлэл түгээх үйл ажиллагаанд MNS 5140:2011, MNS 5552:2005, MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:209; MNS ISO/IEC 13335-1:2009 зэрэг холбогдох стандарт шаардлагыг мөрдөн ажиллана.	Хуучин 3.4 дэх заалтын дугаарлалтыг өөрчилсөн.
43	ДӨРӨВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ</b>	ДӨРӨВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ</b>	
44	4.1.	Мэдээллийн нэгдсэн санг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн болон захиргааны бүх шатны байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор албан ажлын хэрэгцээнд ашиглана.	4.1.	Мэдээллийн нэгдсэн санг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн болон захиргааны бүх шатны байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор албан ажлын хэрэгцээнд ашиглана.	“бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн.
45	4.2.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг солилцохдоо хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн цахим мэдээлэл	4.2.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг солилцохдоо хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн мэдээлэл солилцооны систем болон цаасан хэлбэрээр	“цахим” гэдгийг хасаж, “ба заавал бүртгэл хөтөлнө” гэж нэмсэн.



		солилцооны систем болон цаасан хэлбэрээр дамжуулна.		дамжуулах ба заавал бүртгэл хөтөлнө.	
46	4.3.	Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл ирүүлэхдээ тухайн мэдээллийг ирүүлэх эрх бүхий байгууллагыг төлөөлөх албан тушаалтан гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгийг дарж баталгаажуулна. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн байгууллага хариуцна.	4.3.		
47	4.4.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд ашиглах талаар холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудад хориглосноос бусад мэдээллийг ашиглуулах эсэхийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.	4.4.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд ашиглах талаар холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулиудад хориглосноос бусад мэдээллийг ашиглуулах эсэхийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.	Өөрчлөлт ороогүй.
48	4.5.	Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн цахим мэдээлэл солилцооны системтэй олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлыг хангах, хэвлэн нийтлэх, олон нийтэд сурталчлах талаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн үндсэн дээр цахим хэлбэрээр холбогдож ажиллана.	4.5.	Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн мэдээлэл солилцооны системтэй олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлыг хангах, олон нийтэд сурталчлах талаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн үндсэн дээр цахим хэлбэрээр холбогдож ажиллана	“цахим”, “хэвлэн нийтлэх” гэдгийг хассан.

49	4.6.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн нэгдсэн сан хариуцсан ажилтан нь жил бүрийн эцэст тухайн жилийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, мэдээлэл солилцооны талаарх мэдээллийг эмхтгэж, холбогдох албан тушаалтанд танилцуулна.	4.6.	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн нэгдсэн сан хариуцсан ажилтан нь жил бүрийн эцэст тухайн жилийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, мэдээлэл солилцооны талаарх мэдээллийг дээд шатны албан тушаалтанд танилцуулна.	“бодлого, төлөвлөлтийн”, “нэгдсэн” гэж нэмсэн, “эмхтгэж, холбогдох” гэдгийг хассан.
50	4.7.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцооны системд холбогдох техникийн нөхцөл, ажиллах орчны стандартын шаардлагыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран батална.	4.7.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцооны системд холбогдох техникийн нөхцөл, ажиллах орчны стандартын шаардлагыг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран батална.	“бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн.
51	4.8.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор ашиглах, мэдээлэл солилцохгүй.	4.8.	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор солилцохыг хориглоно.	Өөрчлөлт ороогүй.
52	ТАВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ЭРХ ОЛГОХ</b>	ТАВ	<b>МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ АШИГЛАХ ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ЭРХ ОЛГОХ</b>	
53	5.1.	Энэхүү журмын 4.1, 4.6-д заасан этгээд Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлтийг Үндэсний хөгжлийн асуудал	5.1.	Энэхүү журамд заасан этгээд Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлтийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал	Өөрчлөн найруулсан.

		эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүсэлт гаргана.		эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр гаргана.	
54	5.2.	Мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл авах хүсэлт нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан мэдээлэл ашиглах гэрээг энэ журмын 3.5-д заасан нэгж байгуулна.	5.2.	Мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл авах хүсэлт нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан мэдээлэл ашиглах гэрээг энэ журмын 3.3-д заасан нэгж байгуулна.	“3.3”-ыг “3.5” гэж өөрчилсөн.
55	5.3.	Энэ журмын 5.2-д заасан гэрээнд дараах асуудлыг тусгана:	5.3.	Энэ журмын 5.2-д заасан гэрээнд дараах асуудлыг тусгана:	Өөрчлөлт ороогүй.
56	5.3.1.	мэдээллийн үйлчилгээний хүрээ;	5.3.1.	мэдээллийн үйлчилгээний хүрээ;	Өөрчлөлт ороогүй.
57	5.3.2.	мэдээллийн үйлчилгээний нэр, төрөл;	5.3.2.	мэдээллийн үйлчилгээний нэр, төрөл;	Өөрчлөлт ороогүй.
58	5.3.3.	ашиглалтын зориулалт;	5.3.3.	ашиглалтын зориулалт;	Өөрчлөлт ороогүй.
59	5.3.4.	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага;	5.3.4.	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага;	Өөрчлөлт ороогүй.
60	5.3.5.	мэдээллийн нэгдсэн сан, системийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөл, шаардлага;	5.3.5.	мэдээллийн нэгдсэн сан, системийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөл, шаардлага;	Өөрчлөлт ороогүй.
61	5.3.6.	мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг эзэмшигчийн тоо, албан тушаал, овог нэр, нууц үг;	5.3.6.	мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг эзэмшигчийн тоо, албан тушаал, овог нэр, нууц үг;	Өөрчлөлт ороогүй.
62	5.3.7.	гэрээний төлбөр, нөхцөл;	5.3.7.	гэрээний төлбөр, нөхцөл;	Өөрчлөлт ороогүй.
63	5.3.8.	эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хязгаарлах нөхцөл;	5.3.8.	эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хязгаарлах нөхцөл;	Өөрчлөлт ороогүй.

64	5.3.9.	гэрээний хүчинтэй байх хугацаа.	5.3.9.	гэрээний хүчинтэй байх хугацаа.	Өөрчлөлт ороогүй.
65	<b>ЗУРГАА</b>	<b>МЭДЭЭЛИЙН НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА</b>	<b>ЗУРГАА</b>	<b>МЭДЭЭЛИЙН НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА</b>	
66	6.1.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл, өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, системийн хөгжүүлэлтийг хариуцан ажиллана.	6.1.	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл, системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг хариуцан ажиллана.	“бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн, “өгөгдлийн нууцлал” гэдгийг хассан, “аюулгүй байдлыг” гэж өөрчилсөн.
67	6.2.	Мэдээллийн нэгдсэн сан нь цахим халдлага, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан байх ёстой ба холбогдох хууль, стандартыг мөрдөж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	6.2.	Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны үе шат бүрт мэдээллийн нууцлалыг хангах, цахим халдлага, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан техник, программ хангамжийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх ба зохих хууль тогтоомж, стандартыг мөрдөж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	Бүхэлд нь шинэчлэн найруулсан.
68	6.3.	Байгалийн гамшигт эрсдэл, галын аюул, усны үер, нийтийг хамарсан үймээн самуун зэрэг давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлээс Мэдээллийн нэгдсэн санг хамгаалах менежментийг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.	6.3.	Байгалийн гамшигт эрсдэл, галын аюул, усны үер, нийтийг хамарсан үймээн самуун зэрэг давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлээс Мэдээллийн нэгдсэн санг хамгаалах менежментийг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.	“бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн.
69	6.4.	Энэхүү журмыг зөрчин Мэдээллийн нэгдсэн сангийн	6.4.	Энэхүү журмыг зөрчин Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг хууль	Өөрчлөлт ороогүй.

		мэдээллийг хууль бусаар ашигласан, түгээсэн болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.		бусаар ашигласан, түгээсэн болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.	
<b>70</b>	<b>ДОЛОО</b>	<b>САНХҮҮЖИЛТ</b>	<b>ДОЛОО</b>	<b>САНХҮҮЖИЛТ</b>	
<b>71</b>	<b>7.1.</b>	Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, эрхлэн хөтлөх, удирдах, мэдээллийн болон техникийн нөхцөлийг хэвийн хангах, хадгалах, хамгаалах, нууцлалын найдвартай байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг дараах эх үүсвэрээр тус тус санхүүжүүлнэ. Үүнд:	<b>7.1.</b>	Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, эрхлэн хөтлөх, удирдах, мэдээллийн болон техникийн нөхцөлийг хэвийн хангах, хадгалах, хамгаалах, нууцлалын найдвартай байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг дараах эх үүсвэрээр тус тус санхүүжүүлнэ. Үүнд:	Өөрчлөлт ороогүй.
<b>72</b>	<b>7.1.1.</b>	улсын төсөв;	<b>7.1.1.</b>	улсын төсөв;	Өөрчлөлт ороогүй.
<b>73</b>	<b>7.1.2.</b>	холбогдох төсөл, хөтөлбөр.	<b>7.1.2.</b>	холбогдох төсөл, хөтөлбөр.	Өөрчлөлт ороогүй.
<b>74</b>	<b>НАЙМ</b>	<b>БУСАД</b>	<b>НАЙМ</b>	<b>БУСАД</b>	
<b>75</b>	<b>8.1.</b>	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санг хэвийн ажиллуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд төрийн болон бүх шатны захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдтэй хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.	<b>8.1.</b>	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санг хэвийн ажиллуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд төрийн болон бүх шатны захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдтэй хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.	“бодлого, төлөвлөлтийн” гэж нэмсэн.